

**“ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙГШИНЭЭР
БАЙГУУЛАХЫГ ТҮР ХОРИГЛОХ, ТЭДГЭЭРИЙН ҮР АШИГ, МЕНЕЖМЕНТИЙГ
САЙЖРУУЛАХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСӨЛ
БОЛОВСРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН
СУДЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг шинээр байгуулахыг түр хориглох, тэдгээрийн үр ашиг, менежментийг сайжруулах тухай” УИХ-ын тогтоолын төсөл боловсруулах тухай

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна.” гэж заасан. Бодит байдал дээр манай эдийн засаг төрийн өмч зонхилсон бүтэц тогтолцоотой болжээ.

Нөхцөл байдал ийм болсныг хэдхэн үзүүлэлт тодорхой харуулж байна. Тухайлбал 2012-2021 оны хооронд сүүлийн 10 жилийн хугацаанд төсөвт төвлөрлүүлсэн татварын нийт орлогын 33 хувь нь төрийн өмчийн голлох 107 компанид ноогдож байгаа юм. Гэтэл Монгол Улсын нийт татвар төлөгч аж ахуйн нэгжүүдийн тоо нь 228012 байгаа бөгөөд дээрх 107 компани гэдэг бол нийт аж ахуйн нэгжүүдийн 0.05 хувь юм. Тэгэхээр нийт аж ахуйн нэгжүүдийн 99.95 хувь нь татварын нийт орлогын үлдсэн хэсгийг төлж байна. Татварын төлөлт талаас энэ нь сайн мэдээ мэт боловч Монголын бизнесийн хамгийн өгөөжтэй, хамгийн далайцтай макро эдийн засгийн орчинд бодитоор нөлөөлөхүйц хэсгийг нь нийт компаниудын 0.05 хувь нь буюу төрийн өмчид компаниуд л хариуцан эрхэлж байна. Аж ахуйн нэгжүүдийн 0.05 хувьтай тэнцэж буй энэ нэн цөөнх компаниудын Монгол Улсын экспортод эзэлж буй хувь хэмжээ татварын орлогын хэмжээнд эзэлж буй хувийн жингээс бүр илүү буюу 42 хувь байна.

Зөвхөн энэ үзүүлэлтээс харахад сүүлийн 10 жилд төрийн компаниудын орлого эдийн засагт эзлэх хувийн жин нь эрс нэмэгдсэн нь харагдаж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн засаглалийн үнэлгээний ерөнхий индекс 54 хувьтай байгаа нь хангалтгүй бөгөөд, өнөөгийн нийгэм, эдийн засгийн хурдацтай хөгжил, Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Компанийн тухай хуулийн түвшинд хийгдсэн өмчийн эрх зүйн шинэтгэлээс хоцорч, үндсэн чиг үүргээ хангалттай биелүүлж чадахгүй болсон.

Төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр гаргах эрх мэдэл дутагдаж, Засгийн газар, яамдаас асуудлыг, ялангуяа гэрээ хэлэлцээрийг хойшлуулдаг, шуурхай шийдэж өгдөггүйн улмаас хугацаа алдаж, орлогын төлөвлөгөө тасалддаг, ашиггүй ажилладаг байдал байсаар байна. Мөн Төрийн ба орон нутгийн өмчийн хуулийн этгээд нь нээлттэй, ил тод байдал дутагдсанаас хөрөнгийн үр ашиггүй зарцуулалт бий болох, удирдлагын буруу шийдвэрт хариуцлага тооцдоггүй, ашиг сонирхлын

зөрчил үүсэхэд хүргэж байна. Үүний хамгийн ойрын жишээ нь Хөгжлийн банк бөгөөд ТӨААН-ын менемент ямар суурь дутагдалтай байдгийг харуулж буй юм. Иймээс Төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийг шинээр байгуулахыг хориглох зайлшгүй шаардлага үүсээд байна.

Одоо үйл ажиллагаа явуулж байгаа Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүү, нягтлан бодох хяналтыг сайжруулах, Шинэ сэргэлтийн бодлогын 6.4-т заасны дагуу Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн боломжит хэсгийнх нь хувьцааг Монголын хөрөнгийн бирж дээр гарган арилжиж олон нийтэд нээлттэй хувьцаат компани болгон өөрчлөх бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлага тулгараад байна. Төрийн өмчит хуулийн этгээдийн санхүү, нягтлан бодох хяналтыг сайжруулж олон улсын жишигт хүргэж байж төрийн өмчийн аливаа хулгайгаас сэргийлж чадна.

Гадаадад хувьцаа нь арилжаалагдаж буй Монголд бүртгэлтэй компаниудын хувьцааг Монголын хөрөнгийн бирж дээр арилжаалах эрх зүйн үндсийг тавьсан Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6.3, 6.4 дахь зүйлийн хэрэгжилтийг гүйцэд хангаж ажиллах шаардлагатай байна. Ингэж хангаж ажиллахыг эрчимжүүлэхэд энэхүү Улсын их хурлын тогтоол чухал нөлөөтэй юм.

Иймээс “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үр ашиг, менежментийг сайжруулж шинээр байгуулахыг хориглох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.

УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг шинээр байгуулахыг түр хориглох, тэдгээрийн үр ашиг, менежментийг сайжруулах тухай” УИХ-ын тогтоолын төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагыг Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын /цаашид Аргачлал гэх/ 1.3-т заасан хүрээнд хамаарахгүй тул урьдчилан тандан судлах ажиллагааг Аргачлалын 2.1-т заасан үе шатын дагуу хийж гүйцэтгэлээ.

НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

Тогтоолын төсөлд тусгагдсан арга хэмжээг тодорхойлохдоо хэрэгжихүйц бөгөөд хэмжигдэхүйц, бодитой, хэрэгжилтийн цаглабарыг оновчтой тооцсон байх зэрэг төлөвлөлтийн үндсэн шалгуурыг баримталсан. Экспортыг нэмэгдүүлэх замаар улс орны эдийн засгийн суурийг тэлэн ДНБ нэмэгдэхэд түүнд саад болж байгаа хязгаарлагч хүчин зүйлсийг арилгах, төрийн оролцоог бууруулах зорилтыг тус тус харгалзан үзэж тусгалаа.

Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх, Монгол Улсын Их Хурлаас баталсан “Алсын хараа 2050”-ын эхний үе шатад эдийн засгийн жилийн дундаж өсөлт 6 хувьд хүрч, нэг хүнд ногдох үйлдвэрлэл 3 дахин өсөж, ажиллах хүчний оролцооны түвшин 65 хувьд хүргэх, дундаж ба түүнээс дээш давхаргын иргэдийн эзлэх хувийг 13 хувиар өсгөж хүргэх нэгэн нөхцөл бүрдэх юм.


Иймд Аргачлалын 3-т заасны дагуу асуудалд дүн шинжилгээ хийхдээ асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх гэж байгаа асуудлын мөн чанар, цар хүрээг, тогтоож, тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэн, аж ахуйн нэгж, бусад этгээдийг тодорхойлж, улмаар түүнийг үүсгэж байгаа шалтгаан, нөхцөлийг тодорхойлсон болно.

1.1. Асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлсон байдал:

Тогтоолын төсөл, үзэл баримтлалын төслийг боловсруулахдаа Монгол Улсын статистикийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газрын тоон мэдээлэл болон шилэн дансны мэдээлэл дээр үндэслэлээ.

Сүүлийн 10 жилийн дунджаар авч үзвэл Монгол Улсын төсвийн орлогын 82.8 хувийг татварын орлого, татварын орлогын 33 хувийг төрийн болон орон нутгийн өмчийн 107 компани, үйлдвэрийн газар /ТӨААН/ бүрдүүлж байна. Шилэн дансанд нийтдээ төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой 461 компани, үйлдвэрийн газар бүртгэлтэй байдаг бөгөөд үүнээс томоохон 107 компанийн татварын мэдээлэлд үндэслэн тооцооллоо.

График-1
сая.төгрөг



Дээрх графикаас харахад төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компани, үйлдвэрийн 107 байгууллагын татвар төлөлт 2012 оноос 2015 он хүртэл 41.6 хувь, 2016 оноос 2021 он хүртэл 79.1 хувиар тус тус өссөн байна. Хувийн хэвшлийн болон ТӨААН-ийн татвар төлөлт харьцангуй ижил уялдаатай байгаа боловч 2013-2016 оны хооронд урвуу хамааралтай байна. Өөрөөр хэлбэл 2013-2015 онд хувийн хэвшлийн татвар төлөлт буурч байхад ТӨААН-ийн татвар төлбөр өссөн, харин 2015-2016 онд эсрэгээрээ үзүүлэлттэй байна. Хэдийгээр

2015-2016 онд хувийн хэвшлийн татвар төлөлт өссөн боловч нийт татварын орлого нь ТӨААН-тэй адил буурсан байгаа нь хамаарал өндөр байгааг харуулж байна.

1.2.Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг тодорхойлох:

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь компанийн тухай хууль, төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн хүрээнд үндсэн зохицуулалт хийгддэг бөгөөд тухайлсан үйл ажиллагааны чиглэлээр төрийн байгууллага, иргэн, хувийн болон төрийн өмчийн хуулийн этгээдүүдтэй харилцаанд ордог.

Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч ажил олгогчийн тооноос харахад 2021 оны байдлаар нийт 52754 байгууллага байгаагийн 11.2 хувь буюу 5901 байгууллага нь төрийн болон төрийн оролцоотой байгууллага байна. 2015 онд 5666 байгууллага байсан болн 2021 онд 5901 байгууллага болж 7 жилийн дотор нийт 235 байгууллага шинээр байгуулагджээ. Тухайлбал, 2019 онд 68, 2020 онд 219, 2021 онд 56 байгууллагыг шинээр байгуулсан байна.

7 жилийн математик дунджаар хэлбэл жил бүр 39 байгууллагыг төр шинээр байгуулж байна.

Хувийн хэвшлийн нийгмийн даатгал төлөгч байгууллагын тоо ихсэх нь чөлөөт эдийн засгийн бүтэцтэй улсын хувьд эрүүл, сайн үзүүлэлт бол, жил бүр олон тооны байгууллага шинээр байгуулах замаар төр өөрөө эдийн засгийн хамгийн том оролцогч болж орж ирэх нь маш сөрөг нөлөөлөл үзүүлнэ.



Дээрх графикт хувийн хэвшлийн тооны өсөлт төрийн байгууллага болон ТӨААН-ийн тооны өсөлтөөс хамаагүй өндөр байгаа мэт боловч нийгмийн даатгалын шимтгэл төлөлт, түүнд эзлэх хувь, хэмжээг харахад эсрэг үр дүнг

үзүүлж байна. Энэ нь хувийн хэвшлийн байгууллага олон мэт боловч ажлын байр олноор бий болгох чадамж сул, жижиг бизнес их байгааг харуулж байна. Үүнийг төр, ТӨААН нийт нийгмийн даатгалын шимтгэл төлөгч ажил олгогчийн 12 хувь, харин шимтгэл төлөлтөөрөө 45 хувийг эзэлж байгаа байдлаар нотолж болно.

1.3. Асуудлыг үүсгэж буй шалтгаан нөхцөл:

Нийт татварын орлого/ТӨААН татвар


сая.төгрөг

	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он
Нийт татварын орлого	2,222,293.8	2,668,986.3	2,754,419.5	2,677,934.1	2,336,138.8	3,761,981.4	4,765,508.9	5,739,527.3	5,370,762.8	7,001,411.1
Төрийн өмчит	624,514.3	733,746.7	967,913.3	1,069,409.1	600,036.1	1,200,244.3	1,578,932.8	1,974,808.1	1,787,788.0	2,869,051.1
Төрийн өмчит %	28.1%	27.5%	35.1%	39.9%	25.7%	31.9%	33.1%	34.4%	33.3%	41.0%


Дээрх хүснэгтээс сүүлийн 10 жилд нийт татварын орлогын хэдэн хувийг ТӨААН бүрдүүлж байгааг харж болно.

Харин 10 жилийн дунджаар авч үзвэл 33 хувийг ТӨААН бүрдүүлж байгаа бөгөөд татварт нөлөөлж буй хувь хэмжээ нь эдийн засгийн өсөлттэй хамаарал багатайг дараах графикаас харж болно.


Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт болон ТӨААН-ийн нийт татварын орлогод эзлэх хувь



Дотоодын нийт бүтээгдэхүүнд төр шууд бусаар буюу ТӨААН-ээр дамжуулан нийлүүлэлт хийж байгаа хэмжээ нь сүүлийн 9 жилийн дунджаар 22.3 хувь, шууд байдлаар буюу төсвийн зарлагын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 33.3 хувь байна. Өөрөөр хэлбэл давхардсан тоогоор Төр дотоодын нийт бүтээгдэхүүний 55.6 хувийг дангаараа бүрдүүлж байна.




Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг 2015 оны 2021 онтой харьцуулахад төр, ТӨААН-ийн өсөлт 60 хувь, 57.3 хувь тус тус өссөн байна. Өөрөөр хэлбэл төр, ТӨААН-ийн өсөлт нь хувийн хэвшлийн өсөлтийн хурдаас түрүүлж байна. Ажил олгогч, шимтгэл төлөлтийн энэ дүнгээс харахад Монгол Улсын эдийн засгийн бүтэц төрөөс хэт хамааралтай байгаа, хамаарал сүүлийн жилүүдэд тогтмол нэмэгдэж байгааг харуулж байна.



Монгол Улсын эдийн засаг, гадаад валютын нөөц бүрдүүлэлтийн үндсэн бүрэлдэхүүн хэсэг болох экспортын тоон мэдээлэлд төр, ТӨААН-ийн эзлэх хувь

маш их, өндөр хамааралтай байна. Өөрөөр хэлбэл эдийн засгийн гол үзүүлэлтүүдэд төрийн нөлөө, оролцоо хэт их болсныг харуулж байна. Экспортын 50.7 хувийг төр дангаараа хийж байна. Энэ нь төр, хувийн хэвшилтэй өрсөлдөж гадаад худалдаанд ямар хэмжээнд жин дарсан тоглогч болохыг нотолж байна.



ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОМЬЁОЛСОН БАЙДАЛ

Иймд Аргачлалын 4-т заасны дагуу асуудлыг шийдвэрлэх зорилгыг дараах байдлаар тодорхойлж байна.

Тогтоолын төслийг боловсруулах зорилго нь эдийн засгийн эрүүл бүтцийг бий болгох, Монгол Улсын эдийн засагт төр бус хувийн хэвшил гол тоглогч байж, төр нь хувьтайгаа өрсөлддөг бус, цаашлаад төрийн өмчит компанийн тоог цөөлөх, хөрөнгийн бирж дээр нээлттэй хувьцааг нь арилжихтай холбогдсон харилцааг олон улсын жишигт нийцүүлэн бүрдүүлэхэд оршино.

ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЭРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Асуудлыг шийдвэрлэх боломжтой хувилбаруудыг тогтоож, Аргачлалын 5-д заасны дагуу зорилгод хүрэх байдал буюу эдийн засгийн эрүүл бүтцийг бий болгох, Монгол Улсын эдийн засагт төр бус хувийн хэвшил гол тоглогч байж, төр нь хувьтайгаа өрсөлддөг бус, цаашлаад төрийн өмчит компанийн тоог цөөлөх, хөрөнгийн бирж дээр нээлттэй хувьцааг нь арилжихтай холбогдсон харилцааг олон улсын жишигт нийцүүлэн бүрдүүлэх” зорилгыг хангаж чадах эсэх, зардал, үр өгөөжийн харьцаа буюу хувилбарыг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардал, үзүүлэх эерэг өөрчлөлтийг харьцуулан судалж дараах дүгнэлтийг гаргалаа.

№	Хувилбар	Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
1.	Тэг хувилбар	Өнөөгийн тулгамдаад байгаа хүндрэл хэвээр үргэлжлэх бөгөөд зорилгод хүрэх боломжгүй.	Төрийн өмчит компаниуд улам нэмэгдэж, ашигт ажиллагаа муутай, төсвөөс татаас авч, хувийн хэвшлийн орон зайг багасгана. Эдийн засгийн төрийн хамаарал улам нэмэгдэнэ.	Үр дүнд хүрэхгүй.
2.	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх	Өнөөгийн тулгамдаад байгаа хүндрэл хэвээр үргэлжлэх бөгөөд зорилгод хүрэх боломжгүй.	Төрийн өмчит компани байгуулах, захирал, удирдлага томилох асуудал нь улс төрчдийн сонирхолтой давхцалтай байдаг тул ухуулга явуулах хэмжээнд үр дүн гарахгүй.	Үр дүнд хүрэхгүй.
3.	Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх	Орлого, ашгийн түвшинг тогтоож өгөх, зардлын дээд хэмжээ тогтоох, алдагдалтай компанийг татан буулгах зэргээр зорилгод хүрэхэд дэмжлэг үзүүлэх алхам гаргаж болно.	Маш их хугацаа алдана. Эхний компаниудтай асуудал цэгцлэх ажил эхэлж байхад шинээр жил бүр багагүй компаниуд нэмэгдэн байгуулагдаж байна.	Үр дүнд хүрэхгүй.
4.	Төрөөс санхүүгийн интервенц хийх	Инфляцийн түвшин, төгрөгийн сулрал, төрийн санхүүгийн чадамж нь интервенц хийх боломжийн хийхэд хүндрэлтэй бөгөөд төрийн өмчит компанийн ашигт ажиллагааг сайжруулах, шинээр байгуулахыг хориглоход төрөөс интервенц хийх замаар зорилгод хүрэх боломжгүй.	Үргүй зардал их гарна. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгах боломжгүй.	Үр дүнд хүрэхгүй.
5.	Захиргааны шийдвэр гаргах	Төрийн өмчит компани байгуулахыг хориглох, нээлттэй болгох асуудал нь Улсын Их Хурал тогтоол, хуулиар зохицуулдаг тул	Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгах боломжгүй.	Үр дүнд хүрэхгүй.

		хуулиар эрх олгогдоогүй тохиолдолд шийдвэр гаргах замаар зорилгод хүрэх боломжгүй.		
6.	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Асуудлыг нэгдсэн байдлаар, эрх зүйн баримт бичгийн үйлчлэлийг улсын хэмжээнд ижил мөрдүүлж, ажиллуулах нь УИХ-аас гарах тогтоол байна.	Одоо үйл ажиллагаа явуулж буй байгаа нөөц бололцоонд тулгуурлан хэрэгжүүлэх учир нэмэлт зардал гарахгүй. Улсын төсвөөс татаас авах шинэ компани байгуулагдахгүй болох нь төсөвт эерэг нөлөө үзүүлнэ.	Үр дүнтэй.

Энэхүү тогтоолын төсөл нь доорх 5 асуудлын хүрээнд төвлөрсөн болно.
Үүнд:

1. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд шинээр байгуулахыг 2022 оны сарын өдрөөс эхлэн түр хориглох,
2. Одоо үйл ажиллагаа явуулж байгаа Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагааг олон нийтийн хяналтанд оруулах зорилгоор санхүү, нягтлан бодох хяналтыг сайжруулах, Шинэ сэргэлтийн бодлогын хөтөлбөрийн 6.4-т заасны дагуу Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хувьцааны хэсэгчилсэн болон бүхэлд нь Монголын хөрөнгийн бирж дээр арилжиж олон нийтэд нээлттэй хувьцаат компани болгон өөрчлөн зохион байгуулах бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх,
3. Гадаадад хувьцаа нь арилжаалагдаж буй Монголд бүртгэлтэй компаниудын хувьцааг Монголын хөрөнгийн бирж дээр арилжаалах эрх зүйн үндсийг тавьсан Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6.3, 6.4 дахь хэсгийн заалтын хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах,
4. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг цомхотгон цөөлөх, хувийн хэвшлийн зонхилох байр суурийг нэмэгдүүлэхэд чиглэсэн цогц судалгаа, бодлогыг боловсруулах,
5. Энэ тогтоолыг Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулан холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан шийдвэрлэх

Тогтоолын төсөлд тусгагдсан арга хэмжээг тодорхойлохдоо хэрэгжихүйц бөгөөд хэмжигдэхүйц, бодитой, хэрэгжилтийн цаглабарыг оновчтой тооцсон байх зэрэг төлөвлөлтийн үндсэн шалгуурыг баримталсан. Экспортыг нэмэгдүүлэх замаар улс орны эдийн засгийн суурийг тэлэн ДНБ нэмэгдэхэд түүнд саад болж

байгаа хязгаарлагч хүчин зүйлсийг арилгах, төрийн оролцоог бууруулах зорилтыг тус тус харгалзан үзэж тусгалаа.

Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх, Монгол Улсын Их Хурлаас баталсан “Алсын хараа 2050”-ын эхний үе шатад эдийн засгийн жилийн дундаж өсөлт 6 хувьд хүрч, нэг хүнд ногдох үйлдвэрлэл 3 дахин өсөж, ажиллах хүчний оролцооны түвшин 65 хувьд хүргэх, дундаж ба түүнээс дээш давхаргын иргэдийн эзлэх хувийг 13 хувиар өсгөж хүргэх нэгэн нөхцөл бүрдэх юм.

ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

Аргачлалын 6-д заасны дагуу сонгосон хувилбарын үр нөлөөг Аргачлалд заасны дагуу ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа.

4.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Хувилбар 6-гийн хүрээнд төрийн өмчит хуулийн этгээд шинээр байгуулахыг хязгаарлах замаар хувийн хэвшлийг дэмжих нь эрх зүйн харилцаа илүү боловсронгуй болж, тэгш шударга байдал хангагдах эерэг нөлөөтэй.

4.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Сонгосон хувилбарын хүрээнд эдийн засаг, бизнесийн орчин сайжирч, татварын суурь өргөжнө.

4.3. Нийгэмд үзүүлэх нөлөө

Хувилбар 6-гийн хүрээнд ажил эрхлэлтийн түвшин нэмэгдэж, ажиллагсдын нийгмийн байдал сайжрах дам нөлөө үзүүлнэ.

4.4. Байгаль орчинд үзүүлэх нөлөө

Байгаль орчинд ямар нэгэн шууд болон шууд бус сөрөг нөлөө үзүүлэхгүй.

4.5. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг шинээр байгуулахыг түр хориглох, тэдгээрийн үр ашиг, менежментийг сайжруулах тухай” УИХ-ын тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээнд нийцэх бөгөөд өнөөдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомжийг аливаа хэлбэрээр зөрчихгүй болно.

ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ

Аргачлалын 7-д зааснаар хувилбаруудын эерэг болон сөрөг талуудыг

- Зорилгод хүрэх байдал;
- Зардал, үр өгөөжийн харьцаа;

- Хүний эрх, эдийн засагт, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө;
- Хууль тогтоомжтой нийцэж буй эсэх;
- Гарч болох сөрөг үр дагавар, түүнийг арилгах хувилбар байгаа эсэх гэсэн шалгуураар дахин нягтлан үзэж дараах дүгнэлтийг хийлээ.

Монгол Улсын төрийн бодлоготой уялдуулан эдийн засгийн өсөлт, бизнес эрхлэлтийг дэмжсэн тэгш шударга, өрсөлдөхүйц, олон улсын жишигт нийцсэн эдийн засгийн суурийг төрийн оролцоо багатай, хувийн хэвшил давамгайлсан байдлыг бүрдүүлэхийн тулд зөвхөн хувилбар 6 буюу хууль батлан хэрэгжүүлснээр өнөөгийн тулгамдаад байгаа сөрөг үр дагаврыг бууруулах, зорилтыг хангах боломжтой байна.

Энэхүү зохицуулалтыг хуульд тусгахдаа оновчтой хэлбэрээр хуульчлахгүй бол эдийн засаг, нийгэмд үзүүлэх сөрөг үр дагаврыг нэмэгдүүлэх эрсдэл учирч болох юм.

ЗУРГАА. ЗӨВЛӨМЖ

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг шинээр байгуулахыг түр хориглох, тэдгээрийн үр ашиг, менежментийг сайжруулах тухай” УИХ-ын тогтоолын төсөл боловсруулж батлан гаргах хувилбарыг сонгох нь зүйтэй гэж үзэж байна. Тус тогтоолоор дараах асуудлыг нарийвчлан зохицуулах шаардлагатай байна:

- Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд шинээр байгуулахыг түр хориглох,
- Одоо үйл ажиллагаа явуулж байгаа Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагааг олон нийтийн хяналтанд оруулах зорилгоор санхүү, нягтлан бодох хяналтыг сайжруулах, Шинэ сэргэлтийн бодлогын хөтөлбөрийн 6.4-т заасны дагуу Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хувьцааны хэсэгчилсэн болон бүхэлд нь Монголын хөрөнгийн бирж дээр арилжиж олон нийтэд нээлттэй хувьцаат компани болгон өөрчлөн зохион байгуулах бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх,
- Гадаадад хувьцаа нь арилжаалагдаж буй Монголд бүртгэлтэй компаниудын хувьцааг Монголын хөрөнгийн бирж дээр арилжаалах эрх зүйн үндсийг тавьсан Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6.3, 6.4 дахь хэсгийн заалтын хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах,
- Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг цомхотгон цөөлөх, хувийн хэвшлийн зонхилох байр суурийг нэмэгдүүлэхэд чиглэсэн цогц судалгаа, бодлогыг боловсруулах,
- Энэ тогтоолыг Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулан холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан шийдвэрлэх

Хавсралт

Ашигласан мэдээлэл, судалгаа, гарын авлага:

- Монгол Улсын үндсэн хууль
- Хууль тогтоомжийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Компанийн тухай хууль
- Монгол Улсын статистикийн ерөнхий газрын мэдээлэл
- Татварын ерөнхий газрын мэдээлэл
- Гаалийн ерөнхий газрын мэдээлэл
- Нийгмийн даатгалын ерөнхий газрын тоон мэдээлэл
- Шилэн дансны мэдээлэл